



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/20

Чингис хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж 6 уй “Хэрлэн дом”, “Оюуны шим”, “Ач манал” өрхийн Эрүүл мэндийн төвийн даргатай гурвалсан гэрээ байгуулан, гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллах итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч /М.Шүрэнцэцэг/-ийг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилсонтой холбогдуулан хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн ажил үйлчилгээг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч /М.Шүрэнцэцэг/-д үүрэг болгосугай.

3. Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Л.Мэндбаяр/-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010076